



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 4/245

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/214 дүгээр тушаал, Улсын Онцгой шуурхай штабын даргын 2021 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн баталсан түр заавар, аймгийн Онцгой комиссын шуурхай штабын хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад хяналт тавих, халдваргүйжүүлэлт хийх, гүйцэтгэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох заавар, журмын дагуу байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж, удирдан зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Дорждэрэм)-д, цогцсыг оршуулахад хяналт тавьж, халдваргүйжүүлэлт хийж, гүйцэтгэх ажлыг тухайн иргэний ар гэрийн хүмүүстэй хамтран шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210850